

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны
2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: "АВТО ЗАМ" ХК

Хаяг, утас: Архангай аймаг Эрдэнэбулган сум

Хурал хуралдах огноо, цаг, газар: Архангай аймаг Эрдэнэбулган сум "АВТО
ЗАМ" ХК-ийн байр 2015 оны 6 дугаар сар 15-нд 14 цагт

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: 2015 оны 6 дугаар сар 02 өдөр

Олон нийтэд зарлах огноо: 2015 оны 6 дугаар сар 6 өдөр

Бүртгэх өдөр: 2015 оны 3 дугаар сар 28 өдөр

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх
огноо: 2015 оны 6 дугаар сар 08 өдөр

Хүргүүлсэн огноо

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ширхэг, хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ

КОМИССЫН ДАРГА /*T. Masuregofot*...../

2015 оны *06* дүгээр сарын *02* -ний өдөр

ХҮЛЭЭН АВСАН :

БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН /...../

..... оны дүгээр сарын -ний өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо,
"Монголын хөрөнгийн бирж" ХК-д тус тус ирүүлнэ

“АВТО ЗАМ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 6 сар 02


№ 6/02

Хувьцаа эзэмшигчдийн
хурлыг зарлан
хуралдуулах тухай

2015 оны 4 сарын 25-ны өдөр зарлагдсан “Авто зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирц хуульд заасан хэмжээнд хүрч хурал хуралдуулах боломжтой байсан боловч цөөнхийн төлөөлөл байхгүй, хяналтын багц эзэмшигч тал ирээгүй, ТУЗ-ийн гишүүдийн талаас илүү хувь нь тодорхой шалтгаануудын улмаас хуралд ирж чадаагүй зэрэг байдлыг харгалзан үзээд энэ ээлжит хурлыг хойшлуулсан билээ.

“Авто зам” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас Компанийн хувьцаа эзэмшигчдийн хойшлуулсан хурлыг хуралдуулах талаар хэлэлцэж олонхийн саналыг үндэслэн тогтоох нь:

1. “Авто зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Архангай аймгийн Цэцэрлэг хотод компанийн байранд 2015 оны 6 сарын 15-ны өдөр 14 цагт хуралдуулсугай.
2. Компанийн тухай хуулийн 69.3-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар асуудлыг хэлэлцэх асуудал, Компанийн тухай хуулийн 69.7-т заасны дагуу хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг хэвээр үлдээсүгэй.
3. Хурал зохион байгуулах болон тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хэвээр баталсугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хурлын зар түгээх СЗХ-ны журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 01-р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материалын жагсаалтыг 02-р хавсралтаар, санал авах хуудсын загвар, агуулгыг 03-р хавсралтаар баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай “Авто зам” ХК-ийн байранд ажлын өдрүүдэд 09-16 цагийн хооронд танилцаж болохоос гадна өөрийн харилцдаг брокер дилерийн компаниар дамжуулан танилцаж болохыг дурьдсугай.
7. Санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2015 оны 6 дугаар сар 12 –ний өдрийн 12 цаг байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогийн комиссын даргаар Б.Далхсүрэн, гишүүнээр Б.Анхтуяа нарыг томилсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга  /Б.Т.антөмөр/

